



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 7/101

Мандалговь

“Сүм хөх Бүрдэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх (Адаацаг сум)” –ийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сүм хөх Бүрдэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх /Адаацаг сум”-ийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: М.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)

Гишүүд:

Н.Түвшинжаргал (Иргэний төлөөлөл)

Б.Пэрэнлэймаа (Аймгийн Засаг даргын Тамгын газар Төрийн Захиргаа Удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Сэржмядаг (Аймгийн Засаг даргын Тамгын газар Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Э.Энхжаргал (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (М.Батсайхан)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай хобогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210431